МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 30 өдөр Дугаар А/304 Алтай хот

Комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1.6 дахь заалт, Харилцаа, холбооны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалт, Засгийн газрын 2018 оны "Дүрэм шинэчлэн батлах тухай" 317 дугаар тогтоол, Барилга, хот байгуулалтын сайдын 2018 оны 218 дугаар тушаалаар батлагдсан "Барилга байгууламжийн төвөгшлийн ангиллыг зориулалт, хүчин чадлаар нь тогтоох дүрэм", 2020 оны "Зөвлөмж батлах тухай" 229 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төрийн цахим үйлчилгээг нэвтрүүлэх ХУР систем төслийн хүрээнд Баян-Уул, Жаргалан, Халиун, Цээл, Тонхил, Бигэр сумдад суурилуулсан 20 метр өндөртэй харилцаа холбооны цамхаг угсралт, суурилуулалтын ажлыг хүлээн авч, ашиглалтад оруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга: Б.Бямбадорж -(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга бөгөөд аймгийн Ерөнхий архитектор)

Гишүүдэд: М.Мандаххүү -(аймгийн Засаг даргын Тамгын газрын Архивын тасгийн дарга)

Ж.Бат-Эрдэнэ -(аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн уул уурхай, байгаль орчин, аялал жуулчлалын бодлого хариуцсан мэргэжилтэн)

Ц.Амарсанаа -(Онцгой байдлын газрын гал түймрийн улсын хяналтын байцаагч, хошууч)

C:/My documents/-3A-4 doc

0201000940

Д.Даваасамбуу-(Мэргэжлийн хяналтын газрын харилцаа холбооны хяналтын улсын байцаагч)

Р.Пүрэвдорж -(Орон нутгийн өмчийн газрын өмчийн бүртгэл хяналт хариуцсан мэргэжилтэн)

Ц.Долгорсүрэн -(Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын Стратеги бодлого төлөвлөлтийн газрын мэргэжилтэн)

Д.Цэвэлмаа -("Мэдээлэл холбооны сүлжээ" ТӨХК-ийн ерөнхий инженер)

С.Цэмбэлдорж -(Эрчим төсөл ХХК-ийн инженер) (зохиогч)

Ү.Батзул -(Эйч Ти Эл ХХК-ийн барилгын инженер) (гүйцэтгэгч)

Нарийн бичгийн дарга:М.Мөнхцэцэг -(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын инженерийн барилга байгууламж хариуцсан мэргэжилтэн)

2.Барилга угсралтын ажлыг байнгын ашиглалтад оруулахдаа гэрээнд тусгагдсан техникийн нөхцөл, зураг төсөл, холбогдох баримт бичгийн бүрдлийг хүлээн авч, үр дүнг танилцуулахыг комисс (Б.Бямбадорж)-т үүрэг болгосугай.

3.Орон нутгийн өмчид бий болсон хөрөнгийг хүлээж авсан акт, баримт бичгийг үндэслэн хөрөнгийг бүртгэж, ашиглалтад хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газар (М.Дашпунцаг)-т, барилга байгууламжийн урсгал зардлыг төсөвт тусгаж, цаашдын ашиглалт, арчилгаа, хамгаалалтад хяналт тавьж ажиллахыг "Мэдээлэл холбоо сүлжээ" ТӨХК (Б.Жаргалсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА О.АМГАЛАНБААТАР